



## ГАЗРЫН ТУХАЙ ХУУЛЬ, ТОГТООМЖИЙН ХЭРЭГЖИЛТ, ГАЗАР ОЛГОЛТЫН АСУУДАЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН ГҮЙЦЭТГЭЛ НИЙЦЛИЙН АУДИТ

**Баян-Өндөр сум нь 24,900 га газар нутагтай**

Хөдөө аж ахуйн газар 78.74 га

Хот тосгон, бусад суурины газар 20,356.4 га

Зам, шугам сүлжээний газар 501.04 га

Ойн сан бүхий газар 3,814.96 га

**Жаргалант сум нь 59,500 га газар нутагтай**

Хөдөө аж ахуйн зориулалттай газар 46,190.4 га

Хот тосгон 355.7 га

Бусад суурин, зам, шугам сүлжээний газар 668.3 га

Ойн сан бүхий газар 12,073.14 га



“Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай” гэр бүлийн хамтын хэрэгцээний зориулалтаар 1,655.9 га газрыг 21,141 иргэнд өмчлүүлсэн нь аймгийн нийт хүн амын 17.6 хувийг эзэлж байна.

Аудитаар дараах зөрчлүүд илэрлээ.

Үүнд:

- Иргэнд гэр бүлийнх нь хамтын хэрэгцээнд зориулан газар эзэмшүүлэхдээ төлөвлөгөөнд тусгагдаагүй байршилд эзэмшүүлсэн,
- Хуульд заасан хэмжээнээс хэтрүүлсэн,
- Нийтийн эзэмшлийн бүсэд газар эзэмшүүлсэн,
- Зориулалт өөрчлөх шийдвэр нь хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцээгүй,
- Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөнд нийцүүлэн зориулалт өөрчлөх шийдвэр гаргаагүй,
- Талбайн хэмжээг өөрчлөхдөө төсөвт төвлөрөх орлогыг төвлөрүүлээгүй,
- Төсөвт байгууллагын эзэмшил газар эзэнгүйдсэн,
- Иргэн хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах үйл ажиллагаанд хууль тогтоомжийн дагуу хяналтыг хэрэгжүүлсэн ч хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй.



Аудитын явцад талбайн хэмжээ нэмэгдүүлсэн газрын эрхийн гэрчилгээний үнэ 6 иргэн аж ахуйн нэгжийн 30.94 сая төгрөг, шинээр газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний үнэ 1 аж ахуйн нэгжийн 80.0 сая төгрөг нийт 110.94 сая төгрөгийг төсөвт төвлөрүүлээлээ.

Аудитын дэлгэрэнгүй тайлан  
[open.audit.mn](http://open.audit.mn)

**ЭРДЭНЭТ ХОТ**  
2025 он